



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: ХААИС, Агроэкологийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Агрономи

Индекс: E 08110101

Шинжээчийн баг:

Ахлагч: В.Батцэнгэл (МУИС-ийн Газарзүйн тэнхимийн эрхлэгч)
Гишүүд: И.Отгонбаатар (УХЭШХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга)
Д.Алимаа (МААЭШХ-ийн “Арвин ургацын ундраа” ХХК-ийн захирал)

Улаанбаатар 2020 он

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	ХААИС-ийн Агроэкологийн сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Агрономи	
Индекс	E 08110101	
Шинжээчид	1. В.Батцэнгэл (МУИС-ийн Газарзүйн тэнхимийн эрхлэгч) 2. И.Отгонбаатар (УХЭШХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга) 3. Д.Алимаа (МАНЭШХ-ийн “Арвин ургацын ундраа” ХХК-ын захирал)	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Г.Даваажаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	05/14	Мэргэжилтэн шинжээчдийн нэрсийг хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багт илгээж, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар саналыг хүлээн авах
	05/15	Шинжээчийн багийг томилох
	05/20	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	05/20	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	05/27	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	06/03	Мэргэжилтэн сургууль дээр очиж шинжээч ажиллах бэлтгэлийг хангуулна.
	06/04, 05	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	06/12	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	06/12	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	06/15	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
06/15	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.	

		Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/		БМИҮЗ-өөс эрхлэн мөрдүүлж буй Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд мөрдөх заавар, журмууд, БСШУ-ны Сайдын 2016 оны 02 сарын 19-ний өдрийн А/53 тушаал, Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайлан, Шинжээчийн үнэлгээний тайлан, холбогдох бусад заавар, эрхийн баримт бичиг, БМИҮЗ-ийн Ажлын албаны захирлын 2020 оны А/65тушаал.

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Монгол Улсын Дээд боловсролын түүхэн хөгжилд “Агрономи” мэргэжлийн ангийг 1955 онд нээсэн явдал, улс орны эдийн засаг, нийгмийн чухал салбар болох хөдөө аж ахуйн салбарын үүрэг улам бүр нэмэгдэж буйг харуулсан түүхэн үйл явц болсон. 1958 оны 4-р сарын 15-нд МУИС-ийн гурван (зоо, мал-эмнэлэг, биологи) факультетийг Хөдөө аж ахуйн их сургууль болгон ХААЯ-нд харьяалуулсан байна. Ингэж ХААИС байгуулагдахад агрономийн хөтөлбөрөөр сургалт явуулаад эхэлчихсэн байв.

Агрономи хөтөлбөр 1994 оноос шаталсан сургалт явуулж магистрын хөтөлбөрөөр элсэлт авч эхэлсэн бөгөөд тус хөтөлбөрийн зорилго нь: Агрономийн шинжлэх ухааны судалгааны аргуудыг эзэмшүүлэх, тэдгээрийг ашиглан туршилт судалгааны ажил гүйцэтгэж, үр дүн гаргаж дотоод, гадаадад хөрвөх чадвар бүхий мэргэшсэн боловсон хүчин бэлтгэхэд оршино.

Агрономи магистрын хөтөлбөрөөр 1996-2019 онд агрономч мэргэжлээр 226 магистр төгсөж, Монгол улсын Газар тариалангийн шинжлэх ухаан – сургалт - үйлдвэрлэлийн салбарт амжилттай ажиллаж байна. Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлсэн Ногоон хувьсгал хөтөлбөр, Чацаргана хөтөлбөр, Жимс жимсгэнэ хөтөлбөр, Атрын 3-р аян болон ШУТехнологийн сан, ОУ-ын төслүүдийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, судалгааны үр дүнгүүд нь үйлдвэрлэлд амжилттай хэрэгжжээ. Тухайлбал 1998 оноос хойш доктор, магистр судлаачдын оролцсон үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тос техник, тэжээл, чимэглэлийн ургамлын сорт сорилт, судалгааны ажил амжилттай хийгдэж, үр дүнд 2000-2019 онд Монгол Улсын сорт сорилтын хурлаар нутагшсан болон ирээдүйтэй сортуудыг баталгаажуулж, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн нь ургацын хэмжээг нэмэгдүүлж, хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг хангах таатай нөхцөл бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулсан.

Манай улсын стратегийн гол таримал улаан буудайн ганд тэсвэртэй, ургац арвин, налалт багатай шинэ сортуудыг селекцийн аргаар бүтээх ажилд селекционерүүдийн хамт залуу судлаачид оролцож, Дархан -34, Дархан 74, Дархан 144, Дархан 131, Бурхант -1, арвайн Бурхант -1, Сутай сортуудыг бий болгож, нутагшуулсан нь томоохон амжилт юм. Монгол Улсын сорт сорилтын хурлаар батлагдсан таримал ургамлын нутагшсан болон ирээдүйтэй сортуудын сорт сорилтын судалгааны ажилд докторуудын удирдлаган дор 43 магистр зэрэгтэй агрономичид ажиллажээ.

Одоо тус магистрын хөтөлбөр нь ХААИС, Агроэкологийн сургуулийн Газар тариалан, хөрс судлалын тэнхимд харьяалагдан хэрэгжиж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Дээд боловсролын тухай (2002 оны 5-р сарын 03), Инновацийн тухай хууль (2012 оны 5-р сарын 12), Шинжлэх ухаан, технологийн тухай (2006 оны 12-р сарын 28) хууль
- БСШУ-ны сайдын 2014 оны 09 дүгээр сарын 12-ны А/370 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”
- ХААИС-ийн магистр, докторын сургалтын журам
- Агрономи магистрын сургалтын хөтөлбөрийн иж бүрдэл
- Улс болон бүсийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа
- Монгол улсын ХАА-н үйлдвэрлэл дэх “Агрономи”-ийн салбарын ажлын байрны судалгаа
- “Агрономи”-ийн чиглэлийн магистрын түвшний сургалтын тодорхойлолт, төгсөгчид тавигдах шаардлага, мэргэжилтний загвар. 2018 он
- “Агрономи” чиглэлийн магистрын шатлалын сургалтыг төгсөгчийн эзэмших ур чадваруудын харьцуулсан GAP шинжилгээний дүн
- Агрономи хөтөлбөрийн оролцогч ба сонирхогч талуудаас авсан сэтгэл ханамжийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Агрономи” магистрын түвшний сургалтын хувьд дотоодын өрсөлдөгч байхгүй.
- Сургалтыг онол практикийн хувьд зохистой харьцаагаар явуулдаг.
- Шинэ таримал болон газар тариалангийн үйлдвэрлэлийн шинэ технологиудын чиглэлээр судалгаа явуулдаг.

Анхаарах асуудал:

- Сонирхогч болон ажил олгогч талуудын саналыг хүлээн авч тодорхой хугацаанд хөтөлбөрийн баримт бичгүүдэд тусгаж байх;
- Ахисан түвшний сургалтын хөтөлбөрийн хувьд төгсөгчдийг олон улсын хэмжээнд судалгааны ажил хийх мэдлэг, чадвар арга зүйг эзэмшүүлэхэд анхаарах;
- Суралцагчдын мэргэжлийн гадаад хэл ялангуяа англи хэлний мэдлэгийг сайжруулах тал дээр тодорхой арга хэмжээ авах;

Зөвлөмж:

- Бусад мэргэжлээс Агрономи мэргэжлээр магистрын сургалтад элсэн суралцаж буй суралцагчдад зориулсан тусгай хөтөлбөр боловсруулах;
- Өдрийн байнгын сургалтад суралцах боломжоор хангах;
- Гадаад оюутны тоог нэмэгдүүлэх;

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС болон Агроэкологийн сургуулийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө
- "ХААИС-ийн ХААН кампус" хөтөлбөр, "ХААИС"-ийн дүрэм
- ХААИС-ийн "Агрономи" магистрын сургалтын төлөвлөгөө
- Агрономийн чиглэлийн магистрын хөтөлбөрт "Суралцагч-багш-төгсөгч" судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрөө боловсруулах, сайжруулах ажилд олон талын төлөөллөөс бүрдсэн багийг оролцуулдаг.
- Суралцагчийн хичээл сонголт, сэдэв сонголтыг өргөн хүрээнд, нээлттэй сонгох боломжийг олгодог.
- Агрономийн чиглэлийн бакалаврын хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд оруулахаар бэлтгэж байна.
- Магистрын сургалтыг онол-арга зүй- судалгаа-үйлдвэрлэл гэсэн түвшнээр олон улсын жишигт нийцсэн хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх зорилт тавьсан.

Анхаарах асуудал:

- Олон улсын жишигт хүрсэн, салбарын тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн хөтөлбөртэй болох зорилтоо хэрэгжүүлэх тодорхой төлөвлөгөө гарган ажиллах;
- Органик хөдөө аж ахуйн цэвэр бүтээгдэхүүнээр улс орноо хангах зорилтыг хөтөлбөрийн цаашдын шинэчлэл, сайжруулалтыг хийхдээ бүрэн тусгах;

Зөвлөмж:

- Төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллага холбоодтой нягт хамтран ажиллах, үйл ажиллагааны тодорхой хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх;
- Мэргэжлийн хүрээ болон сонирхлын бүх бүлэгт хөтөлбөрийн зорилго, гарах үр дүнгийн талаарх мэдээллийг хүргэх, тухайн хөтөлбөрөөр суралцагч болон багшлах боловсон хүчинд сайтар ойлгуулан таниулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх;

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн Захирлын 2015 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/219 тоот тушаалын хоёрдугаар хавсралт
- Агрономи хөтөлбөрийн хорооны 2017 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрээр төлөвлөгөөнд орсон өөрчлөлт
- 2014 оны шинэчлэн батлагдсан хөтөлбөрийг МДС-ийн захирал болон сургалтын алба, бүрэлдэхүүний сургуулиудын эрдэм шинжилгээ эрхэлсэн орлогч захирал, хөтөлбөрийн хороо түүний гишүүдийн хамтарсан хуралдааны шийдвэр, 2017, 2018 онуудад хийсэн өөрчлөлт
- ХААИС-ийн Агрономи магистрын сургалтын хөтөлбөр

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагыг төлөвлөхдөө нийгмийн хэрэгцээ шаардлагад үндэслэн хөтөлбөрийг 2-3 удаа шинэчилсэн.
- Тухайн хөтөлбөрөөр дэлхийд тэргүүлэх Канадын Саскачеваны Их Сургууль, ОХУ-ын Тимирязевийн Академийн магистрын хөтөлбөрүүдтэй харьцуулж жишин ялгаатай ба адил, давуу ба дутагдалтай талуудаа тодорхойлсон.

Анхаарах асуудал:

- Хамтран ажилладаг гадаад дотоодын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ хэлэлцээр, баримт бичгүүдээ шинэчлэх, баталгаажуулах тодорхой хугацааны төлөвлөгөө гарган ажиллах.

Зөвлөмж:

- Шинжлэх ухаан технологийн хурдацтай өөрчлөлт, улс орны хөгжлийн төлөвлөлт, хэрэгцээ, шаардлагатай уялдуулан хөтөлбөрийн шинэчлэл хийх бэлтгэлийг хангах

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэлт

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй, суралцагчийн үнэлгээ (PDCA)
- “Агрономи” магистрын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, хичээлүүдийн тодорхойлолт
- Сургалтын технологитой холбоо бүхий баримт бичгүүд
- Зайны болон цахим хичээлүүдийг E-контент түвшинд боловсруулж сургалтад ашигласан байдал
- Сургалтад ашигласан цахим хичээлүүд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Агрономи хөтөлбөрөөр магистрантурт суралцагчид нь туршлага судалгааны ажлаа сургалт судалгаа үйлдвэрлэлийн Нарт, Өнжин, Агропарк төвүүд болон мэргэжлийн бусад хамтран ажилладаг байгууллагууд дээр тогтмол явуулдаг.

Анхаарах асуудал:

- Сургалтын хөтөлбөртөө механикжуулалт, техник технологийн шинэчлэлтэй холбоотой хичээлүүдийг нэмж оруулах;
- Хичээлийн хөтөлбөртөө орчин үеийн техник технологитой танилцах, практик дээр тэдгээртэй бие даан ажиллах цагийг нэмэгдүүлэх;

Зөвлөмж:

- Сургалтын чанарыг сайжруулахын тулд дадлага практикийн хичээлийг явуулах орчин нөхцөлийг сайжруулах;
- Орчин үеийн техник тоног төхөөрөмжөөр хангах тэдгээрийг худалдан авах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох;
- Улс орны хувьд зайлшгүй хэрэгцээтэй мэргэжилтнүүдийг бэлтгэхэд ХААИС-ийн зүгээс болон холбогдох яам, төрийн зүгээс тодорхой дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- 2014 оны индекс батлах БСШУЯ-ны сайдын А/370 тоот тушаалын дагуу 2017 оны 01 сарын 30-ны ХААИС-ийн захирлын тушаалаар батлагдсан хөтөлбөр боловсруулах журмын дагуу боловсруулж 2018 оны 01 сарын 14-ны хурлаар хэлэлцэж шинэчлэн баталсан Агрономи мэргэжлийн хөтөлбөр.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж буй үзэл баримтлал, сургалтын арга зүй, үнэлгээний систем
- Мэргэжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ашиглаж буй Агроэкологийн сургуулийн Ургамлын стрессийн лаборатори, Ургамлын ургуулангийн өрөө, Биологийн хамгааллын лаборатори, Өвчин судлалын, Шавьж судлалын кабинет, Микробиологийн лаборатори, Хөрс, агрохимийн, Гео мэдээллийн 1,2 зэргийн лабораториуд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Зориулагдсан орчинд болон туршилтад суурилсан сургалтыг явуулж улмаар үр дүнгээ судалгаа - үйлдвэрлэлд шууд нэвтрүүлэхэд сургалтаа чиглүүлдэг.
- Агрономи магистрын хөтөлбөрт үнэлгээний шинэ хэлбэр болох One miss программыг нэвтрүүлсэн.
- Идэвхтэй сургалтын шинэлэг аргуудыг хэрэглэдэг.

Анхаарах асуудал:

- Ахисан түвшний сургалтад зориулсан сурах бичиг гарын авлагыг нэмэгдүүлэх;
- Хичээлийн хөтөлбөртөө орчин үеийн техник технологитой танилцах, практик дээр тэдгээртэй бие даан ажиллах цагийг нэмэгдүүлэх;

Зөвлөмж:

- Мэргэжлийн сурах бичиг бичих, хэвлүүлэх чиглэлээр тодорхой хөтөлбөр гарган ажиллах, багш нарт дэмжлэг үзүүлэх

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БСШУЯ-ны сайдын 2003 оны 158 дугаар тушаалаар батлагдсан “Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, суралцагчийн мэдлэг, чадварыг дүгнэхэд баримтлах журам”
- ХААИС-ийн суралцагчийн үнэлгээний систем

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутныг үнэлэхдээ хөтөлбөрөөр эзэмших үндсэн 5 ур чадвараар явцын болон эцсийн үнэлгээг гаргадаг.
- Оюутны гүйцэтгэсэн туршилтын ажлыг хүлээн авахдаа акт үйлдэж нийт гишүүдийн дүнгийн дунджаар үнэлгээ өгдөг.

Анхаарах асуудал:

- Туршилтын хугацаанд багш, удирдагч нараас өгсөн арга зүйг ямар хэмжээнд хэрэгжүүлж технологийн горимын дагуу явуулж байгаа эсэхэд байнгын хяналт тавих

Зөвлөмж:

- Хамтран ажилладаг гадаадын их дээд сургуулиудын суралцагчийн үнэлгээний системээс авч ашиглах боломжтой аргуудыг өөрийн сургалтад ашиглах

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Агроэкологийн сургууль нь ХААИС-ийн төв байрны баруун жигүүрийн 1,2,3 дугаар давхруудад байрлах нийт 32 өрөө тасалгааг /газар тариалан-хөрс судлал, таримал судлал-ой-ландшафтын архитектурын тэнхимүүд/ эзэмшиж үйл ажиллагаагаа явуулах нөхцөлүүдийг бүрдүүлжээ. Багш нарын өрөө 8, лекцийн тэнхим 4, семинар дадлагын кабинет 11, сургалт, судалгааны лаборатори 8, эрдмийн зөвлөлийн өрөө 1 байгаа болон нэг багшид оногдох өрөө нь 5.2 м², нэг оюутанд хичээлийн ангийн 1 м² талбай байна.
- 2017 онд магистрант, докторантуудын судалгааны ажилд зориулж 164 тоот лабораторийг 118.0 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр шинэчлэн сайжруулсан байна.
- Тус сургууль нь Ургамлын өвчин судлалын лабораторийг Солонгос улсын Сөүлийн их сургуулийн төсөл хэрэгжүүлэхэд 40 сая/төг, хөрс-агрохимийн болон гео мэдээллийн лабораториудыг шинэчлэн сайжруулахад нийт 52 сая/төг санхүүжилт хийгджээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлох зүйл/Туршлага:

- 2018 онд хөрс-агрохимийн лаборатори Монгол Улсын Стандарт хэмжил зүйн газрын MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлага хангаж магадлан итгэмжлэгдэж баталгаажсан нь улсын хэмжээний хөрсний задлан шинжилгээг баталгаатай явуулах тоног төхөөрөмж, дэлхийд мөрдөгдөж байгаа хөрсний судалгаа, шинжилгээний арга зүйг эзэмшсэн мэргэшсэн боловсон хүчний нөөцтэй болсныг тодорхойлохоос гадна ахисан түвшний магиструудын судалгаа шинжилгээний ажлыг явуулах боломжийг бүрдүүлсэн орчин, сайжруулсан лабораторитой болжээ.

Анхаарах асуудал:

- Лабораторид ажиллах судлаачдыг химийн бодистой болон тоног төхөөрөмжтэй ажиллах журам дүрэмтэй сайн танилцуулж гарын үсэг зуруулж баталгаажуулах.

Зөвлөмж:

- Ахисан түвшинд суралцаж байгаа судлаачдыг лабораторид судалгааны арга зүйг сайн эзэмшүүлэн, гадаадын их дээд сургуулиуд шиг бие даан ажиллуулж судалгааны анхдагч материалуудыг бүрдүүлэхээс гадна удирдагч багш хяналт тавьж ажиллуулах.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, орчин үеийн тариалангийн нэвтэрч байгаа дэвшилтэт технологи, шинэ хандлага зэрэгт тулгуурласан Агрономи хөтөлбөрт багтдаг 10 хичээлийн стандарт хөтөлбөрийг шинэчилж е-хичээлийн иж бүрдлийг шинэчлэн боловсруулж сургалтандаа ашиглаж эхэлсэн байна.
- Агроэкологийн ахисан сургалтад хичээл заадаг багш нар компьютер болон бусад дагалдах хэрэгслээр зохих түвшинд хангагдсан байна. Багш нарын өрөө, хичээлийн тэнхимүүд интернетийн сүлжээтэй. 2014 оноос сургуулийн интернетийн хичээлээ ppt, аудио, видео хэлбэрээр явуулах боломжийг бүрдүүлжээ. 2014-2015 оны хичээлийн жилд байгуулагдсан 50-60 оюутан нэг дор үйлчлүүлэх хүчин чадалтай, техник технологийг сайжруулсан байнгын ажиллагаатай интернет кафе ажиллуулж байгаа ажээ.
- Улаанбаатар хотын Зайсангийн аманд Газар тариалан, ургамал хамгааллын тэнхим нь 1480 м² талбай бүхий 15 хүлэмж, 2000 м² ил талбайн услалтын систем, 0,7 га талбай бүхий агропарк судалгаа, шинжилгээний ажил явуулж байна. 2015 онд БНСУ-ын Койка байгууллагын тусламжтайгаар 200м.кв талбай бүхий бүрэн автомат шилэн хүлэмж 120 м.кв талбайтай 2 хүлэмж нийлэг хальсан хүлэмж байгуулсан

байна.2015 онд ХХААЯ-ны хөнгөлөлттэй үнээр бага оврын трактор , мотоблок тус бүр нэгийг АБС-ийн санхүүжилтээр авч материаллаг баазаа бэхжүүлсэн байна.

- 2017 онд төгсөгчдийн хандивын 3 сая/төг-өөр “Хээрийн сургалтын танхимыг” засварласан. Францын JERES 0 гаруй сая/төг-ийн санхүүжилтээр 120 м.кв талбайтай өвлийн хүлэмж барьж ашиглалтад оруулсан. Түүнчлэн 100 гаруй мэргэжлийн ном бүхий номын санг бүрдүүлж байгуулсан байна.
- Төв аймгийн Борнуурын нутаг дэвсгэрт байрладаг тус сургуулийн Нарт төв, 230 га тариалангийн үйлдвэрлэл, туршилт судалгааны ажил явуулах талбайтай, ХАА-н техник тоног, төхөөрөмжтэй
- “НАРТ” үйлдвэрлэл- туршилт судалгааны төвд 2013 онд 100 оюутны багтаамж бүхий байр, 2014 онд сургалт болон үйлчилгээний танхим, зоорь, гүний худгууд, 2015 онд нар, салхины хосолсон цахилгаан үүсгэвэр, хээрийн судалгааны лаборатори, сургалт болон үйлчилгээний танхим, 2016 онд автомат хүлэмж дагалдах хэрэгслүүд, хөрс боловсруулах арчилгааны иж бүрдэл техникүүд, сүүлийн үеийн өндөр хүчин чадалтай трактортай болж, бүх байрандаа засвар хийж материаллаг бааз болон багш, оюутнуудынхаа ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулахад дэс дараатай хөрөнгө оруулалтыг хийсэн байна.
- ХААИС-ийн Төв аймгийн Борнуурын Өнжин дэх сургалт, үйлдвэрлэлийн төв нь 36 га талбайтай 2013 онд бордооны агуулах, 50 оюутны багтаамжтай байр, 2014 онд 1 га-ийн услалтын систем ,трактор, анжис , 50 оюутны багтаамжтай байр, 2016 онд гүний худаг, 60 м.кв хүлэмж, жимсний мод 2700 үржүүлгийн талбай, бусад ургамлын үрийн нөөцтэй болсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- НАРТ “ үйлдвэрлэл- туршилт судалгааны төвд 2013 онд 100 оюутны багтаамж бүхий байр, 2014 онд сургалт болон үйлчилгээний танхим, зоорь, гүний худгууд, 2015 онд нар, салхины хосолсон цахилгаан үүсгэвэр, хээрийн судалгааны лаборатори, сургалт болон үйлчилгээний танхим, 2016 онд автомат хүлэмж дагалдах хэрэгслүүд, хөрс боловсруулах арчилгааны иж бүрдэл техникүүд, сүүлийн үеийн өндөр хүчин чадалтай трактортай болж, бүх байрандаа засвар хийж материаллаг бааз болон багш, оюутнуудынхаа ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулахад дэс дараатай хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

Анхаарах асуудал:

- Ургамал газар тариалангийн хүрээлэнгээс гадна Ургамал хамгаалал, Мал аж ахуйн хүрээлэнгийн Бэлчээр тэжээлийн салбартай хамтран ажиллаж ахисан түвшний суралцагчдад хүрээлэнгүүдийн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнтэй байнгын танилцуулж байх шаардлагатай байна.
- ХАА-н техник , тоног төхөөрөмж, трактор, комбайн дээр ажиллах хүмүүст техник дээр ажиллуулахын өмнө техник, аюулгүй байдлын дүрэм, журмыг тогтмол танилцуулж гарын үсэг зуруулж байх шаардлагатай.

Зөвлөмж:

- Тэжээлийн олон наст ургамлын нутгийн 10 гаруй сорт болон гадаадын нутагшсан сортуудыг тариалсан туршлага, судалгааны талбайн фон бий болгож суралцагчдад танин мэдүүлэх, энэ чиглэлийн хичээлийн цагийг нэмэгдүүлэх шаардлагатай нь малын тоо толгой өссөн, өндөр ашиг шимтэй гадаадын төрөл бүрийн мал оруулж ирж байгаатай холбогдуулан тэжээлийн ургамлын өндөр ургацтай уургийн агууламж өндөр шинэ таримлын нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх шаардлагатай байна.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС -ийн төв номын сан 4 салбар номын сантай, 10 фонд, 9 уншлагын танхим 19 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.
- 2018 оны 3 сарын байдлаар 200.0 мянган номын сан хөмрөгтэйгөөс: 175.5 мянган боть ном сурах бичиг байна гэжээ. Санд байгаа номын 36 хувь нь монгол хэл дээр, буюу гуравны нэгээс илүү хувь нь орос хэл дээр, 10 хувь нь англи хэл дээр бичигдэн хэвлэгдсэн байгаа ч агрономийн мэргэжлийн чиглэлийн ном сурах бичиг цөөхөн байна. Өөрийн үнэлгээний тайлангийн 58-72 хуудсанд дэлгэрэнгүй тусгагдсан байна.
- Үндсэн мэргэжлийн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс багш нарын хандиваар бүрдүүлсэн номын санг сургалт, үйлдвэрлэлийн төвүүд дээр байгуулсан байна. Энэ хүрээнд 200 гаруй мэргэжлийн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлээр номын сангуудаа баяжуулснаар Агрономи магистрын хөтөлбөрийн оюутнууд ашиглах бүрэн боломжтой байна.
- 2014 онд ургамлын аж ахуй, газар тариалангийн чиглэлээр шинээр хэвлэгдсэн 4 сурах бичгээс тус бүр 10, нийт 40 ш, 2015нэг нэр төрлийн 10ш номоор сурах бичгийн фонддоо баяжилт хийсэн байна.
- 2015-2017 онд эрдэм шинжилгээний гүйцэтгэлээс үзэхэд 4 багш 3 монограф, 12 багш 10 ном сурах бичиг, гарын авлага туурвиж 5 багш 5 гарын авлагыг орчуулан хэвлүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Агроэкологийн сургуулийн багш нар өөрсдийн туурвисан бүтээлээрээ үндсэн мэргэжлийн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа хүртээмж хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс багш нарын хандиваар бүрдүүлсэн номын санг сургалт, үйлдвэрлэлийн төвүүд дээр байгуулсан байна. Энэ хүрээнд 200 гаруй

мэргэжлийн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлээр номын сангуудаа баяжуулснаар Агрономи магистрын хөтөлбөрийн оюутнууд ашиглах бүрэн боломжтой байна.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн ном, сэтгүүлийг гадаад болон дотоодын эрдэм шинжилгээний байгууллагын жил бүр гаргадаг бүтээл, ном, товхимол, зөвлөмж, заавар, гарын авлагаар /тодорхой тоогоор/ номын фондоо баяжуулж байх шаардлагатай байна.

Зөвлөмж:

- Профессор С.Ичинхорлоо багшийн судалгаа шинжилгээ болон ном, товхимлын нэгдсэн бүтээлээр 2019 онд хэвлүүлсэн **“Хөдөө аж ахуйн мэргэд” II боть** бүтээлээ тогтмол үргэлжлүүлэн, проф. Л.Товуу, С.Бадам, Чогсомжав багш болон бусад ахмад эрдэмтэн багш нарынхаа бүтээлийг хэвлүүлэх ажлаа үргэлжлүүлэн тасралтгүй явуулбал түүхэн бөгөөд залгамж халаа ирээдүйн мэргэжилтнүүдэд ихээхэн ач холбогдолтой, томоохон цар хүрээтэй ажил болно.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Тус сургууль нь 2006-2007 оны хичээлийн жилээс цахим их сургуульд зориулагдсан сургуулийн бүртгэл мэдээллийн цахим хэлбэрт шилжүүлсэн, сургалтын алба, багш, оюутан удирдлага хоорондын харилцаа холбоог уян хатнаар шийдэж чадсан программ хангамжийн иж бүрдэл Сольюшин ХХК-ийн бүтээсэн One MIS программ хангамжийг ашиглаж байна.
- Тус сургуульд ажиллаж байгаа багш нараас шинжлэх ухааны доктор 1, боловсролын доктороос дээш зэрэгтэй багшийн эзлэх хувь 73,5 хувь, дэд профессор цолтой багш 5, профессор цолтой багш 2 ажиллаж байгаа болон эрдмийн цол зэрэгтэй багшийн эзлэх хувь 46.6 байгаагаас үзэхэд багш нарын чадварын үнэлгээ сайн бүрэлдэхүүнтэй байна .

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Агрономи” мэргэжлийн хөтөлбөрийн стратеги төлөвлөгөөг боловсруулан гаргаж, түүндээ хүрэх зорилго, зорилтуудын хүрээнд ахиц гарган ажиллаж тайландаа тусгаж ажилладаг болохоор ажиллахаар санаачлан ажиллах юм байна.

Анхаарах асуудал:

- Газар тариалангийн үйлдвэрлэлийн ажил нь хавраас–намар дуустал үйл ажиллагаа явуулдаг тул магистрантын хичээл эхлэх, дуусах хугацаа болон хамгаалах хугацааг өөрчлөх шаардлагатай байна.
- Хээрийн туршлага судалгааны ажлыг 2-3 жил явуулж судалгааны, анхдагч материал цуглуулж бүтээлээ туурвих энэ судалгаа шинжилгээний байгууллагуудад ажиллаж байгаа хүмүүст хамаарахгүй үйлдвэрлэлийн нөхцөлд ажиллаж байгаа магистрантууд онцгой анхаарах шаардлагатай байна.

Зөвлөмж:

- Магистрантын сургалтын программдаа туршлагын арга зүй, анхдагч материал цуглуулах, тоон боловсруулалтаар баталгаажуулах, хэвлэлийн материал ашиглах, зэрэг судалгаа шинжилгээний ажлын шинэ олон арга зүй эзэмшүүлэх чиглэлээр хичээлд түлхүү оруулах шаардлагатай байна.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Тус сургууль нь Солонгос улсын Кёнсан аймгийн ХАА-н хүрээлэн, КОЙКА олон улсын байгууллага, AFASI олон улсын байгууллага, Японы Сайтамагийн их сургууль, Мицүй ба сан, Жайка олон улсын байгууллага, Германы Вайнштеланы мэргэжлийн дээд сургууль, ХАА Яам, сайн дурын нийгэмлэг, Францын АCF олон улсын байгууллага, Оросын болон Монголын бэлчээр, усжуулагчдын судлаачдын баг зэрэг гадаад, дотоодын 12 байгууллагатай хамтран төслүүдийг хэрэгжүүлснээр мэргэжлийн хөтөлбөрийн гадаад харилцаа өргөжиж багш, оюутны солилцоо, мэргэжил дээшлүүлэлт нэмэгдсэн байна.
- Сүүлийн 5 жилд мэргэжлийн хөтөлбөрийн багш нар гадаадын 6 улсад давхардсан тоогоор 55 удаагийн сургалтад хамрагдсан байна.
- Монгол Улсын эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, Ногоон алт төсөл, гарааны Монгол экологийн бордоо ХХК, Энсада ХХК, Гацуурт, Монголын агрономчдын холбоо зэрэг 15 байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хэлцэл байгуулан, ажлаа дүгнэж ажилласан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- ХААИС-ийг төгсөөд тус сургуульдаа ажиллаж байгаад гадаадын их дээд сургуульд суралцан доктор хамгаалсан багш нар гадаад хэлний түвшин дээшилж, сайн эзэмшсэнээр суралцаж байсан сургуультайгаа хамтран ажиллах гэрээ хэлэлцээр хийж олон улсын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр судалгааны материаллаг баазыг бэхжүүлэх, орчин үеийн тоног төхөөрөмжөөр лабораториудыг тодорхой хэмжээгээр болон иж бүрэн тохижуулах ажлуудыг сайн зохион байгуулж байна.
- Тус сургуулийг Агрономи мэргэжлээр төгсөөд эх орныхоо газар тариалангийн үйлдвэрлэлд ажиллаж байгаа мэргэжилтэн компани захирлууд сургуулийнхаа багш, хамт олонтойгоо эргэн холбогдож гэрээ, хэлцэл хийж хамтран ажиллаж байгаа болон багш, шавийн холбоог бэхжүүлэх тал дээр сайн зохион байгуулан ажиллаж байгаа зэрэг авч хэрэгжүүлэх олон туршлага байна.

Анхаарах асуудал:

- Гадаад дотоодын төсөл, хөтөлбөрийн хэмжээнд хөрөнгө оруулалтаар оруулж ирсэн ХАА-н техник тоног, бүртгэлжүүлж, төхөөрөмжийг үр ашигтай, урт удаан хугацаанд ажиллуулахаас гадна орчин үеийн өндөр хүчин чадалтай ХАА-н техникүүдийг оруулж үйлдвэрлэлд нэвтрүүлж байгаа компаниудтайгаа хамтран ажиллах боломжийг судлах.

Зөвлөмж:

- ХАА-н чиглэлийн улсын хэмжээний захиалгат болон суурь судалгааны ажил явуулдаг газар тариалан, ургамал хамгаалал, бэлчээрийн чиглэлийн судалгаа - шинжилгээний ажил явуулдаг 3 эрдэм шинжилгээний байгууллагад залгамж халаа эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх зайлшгүй шаардлагатай байгааг харгалзан 1-р курсээс эхлэн эрдэм шинжилгээний хүрээлэн болон ахмад докторуудын судалгааны ажилд туслуулан бакалавр цаашлаад магистр болон докторын зэрэг хамгаалах хүртэл цөөн тооны оюутнуудыг мэргэшүүлэх ажлуудыг урт хугацаанд тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Ахисан түвшний суралцагчид гадаадын ямар нэг хэлээр мэргэжлийн ном, сэтгүүл ашигладаг, өөрсдийнхөө судалгаа шинжилгээ болон албан ажлаа танилцуулах хэмжээнд хүртэл шаардлага тавьж ажиллуулахад анхаарах.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Зах зээлийн өрсөлдөөний нөхцөлд суралцагчдыг татах явдал чухал. Иймээс сургалтын төлбөрийг ашигтай арга ажиллагаанд зарцуулж, үргүй зардлыг багасгаж оюутанд үзүүлэх үйлчилгээний чанар, үр ашигт анхаарч ажилладаг байна.
- Төгсөгчид, компанийн захирал, менежер, агрономичид, фермерүүдийн мэргэжлийн хичээл бүрээр тодорхойлж түүнд тулгуурлан тэнхимийн жилийн төсвийг хийж сургалтын ажилд зарцуулдаг. Мэргэжил дээшлүүлэх болон давтан сургах, богино хугацааны сургалтын хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлж ажилладаг байна.
- Нэг кредитийн үнэлгээг мэргэжлийн хичээл бүрээр тодорхойлж түүнд тулгуурлан тэнхимийн жилийн төсвийг хийж сургалтын ажилд зарцуулдаг.
- Нэг кредитийн үнэлгээ тодорхой хувиар өөрчлөгдөж байгаа ба 2014-2015 оны хичээлийн жилд 13 хувь байсан бол бусад жилүүдэд 13.8 хувийн өсөлттэй байжээ.
- Сургалтын төлбөрийг тогтоохдоо цалин 60.3 хувь, үндсэн хөрөнгө болон түүнтэй холбоотой хөрөнгө оруулалтын зардал 4 хувь, хичээл дадлагын зардал 8.9 хувь, үйл ажиллагаатай холбоотой зардал 16 хувь гэж оролцуулан тооцдог байна. ХААИС-ийн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж баталсны дараа мөрдөн ажилладаг.

- Нэг суралцагчийн жилийн төлбөр 2017- 2018 оны байдлаар 2.874.300 төгрөг, нэг кредитийн үнэлгээ 87100 төг байна. Сүүлийн жилүүдэд сургалтын төлбөр, нэг кредитийн үнэлгээ огцом өсөөгүй тогтвортой байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Агроэкологийн сургууль нь Төв аймгийн Борнуурын Нарт, Өнжинд сургалтын дадлага явуулдаг 260 га тариалангийн талбай , худаг, техник тоног төхөөрөмжийг ахмад эрдэмтэн багш Б.Дорж, А.Чойжамц нар найдвартай эх суурийг тавьж цаашид багш доктор Даваа, Солонго нар 10 гаруй жил тогтвортой удирдан ажиллаж оюутнууд байнгын дадлага хийдэг, ашигтай орлоготой ажиллуулж байсан сайхан туршлага бүхий ажлууд байна.

Анхаарах асуудал:

- Сургуулийнхаа харьяа сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн төвүүдээ ашигтай, орлоготой, бие даасан тамгатай, тэмдэгтэй болгож ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх

Зөвлөмж:

- Агроэкологийн сургуулийнхаа санхүүжилтийг нэмэгдүүлэх үйл ажиллагаагаа идэвхжүүлэхийн тулд судалгаа, үйлдвэрлэл явуулж байгаа 3 газраа төлөвлөгөөтэй ашиг, орлоготой ажиллуулж зардлаа ХААИС-ийн захиргаанаас хамааралгүйгээр олж бие даан ажиллуулах бололцоотойг ашиглах, ажлыг зохион байгуулах.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Магистрын хөтөлбөрт элсэгч нь бакалаврын болон түүнтэй дүйцүүлэх боловсрол эзэмшсэн байна. Элсэгч нь өмнө эзэмшсэнээс өөр мэргэжлээр магистрын хөтөлбөрт хамрагдах бол сургалтын агуулгын залгамж чанарыг хангахад шаардагдах хичээлийг урьдчилан судална. Нөхөн судлах хичээлийг хөтөлбөрийн хороо тогтоодог ба дээрх хичээлийн багц цаг нь тухайн сургалтын хөтөлбөрийн үндсэн багц цагт тооцдоггүй байна.
- Хөтөлбөрийн онцлогоос хамааран элсэгчдэд хөтөлбөрийн хороо болон сургуулийн зүгээс бусад нэмэлт шаардлага тавьж болдог ба энэ нь олон улсад баримталдаг нийтлэг жишгийг мөрдөн ажилладаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн тогтвортой байдлын талаар тайланд тодорхой тусгах шаардлагатай.

Зөвлөмж:

- Тус сургуулийн бакалаврын сургалтыг төгссөн магистрантууд ахисан түвшний сургалтад бакалаврт зааж байсан зарим хичээлийн агуулга давтагдан ордог гэсэн санал гомдол их байдгийг харгалзан зарим ахисан түвшний сургалтын хөтөлбөрүүдийн агуулгыг дахин хянан үзэх шаардлагатай.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- “Агрономи” мэргэжлийн хөтөлбөрийн хорооны идэвхжүүлэлтийн төлөвлөгөөний дагуу газар тариалан бүхий аймгуудын ерөнхий агрономитой гэрээ байгуулан төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал, мэргэжилтнүүдийнхээ карьерын өсөлтийн байдал, төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх хэрэгцээ, шаардлага ажлын байрны судалгаа зэрэг холбогдох мэдээллийг авч ажилладаг байна.
- Багш нарын оролцсон төсөл, хөтөлбөрийн тоо жилээс жилд нэмэгдэж 2013 онтой харьцуулахад 2017 онд 11 ажил буюу 27,7 хувиар нэмэгдсэн байна. Мэргэжлийн хөтөлбөрийн хичээл заадаг багш нар өөрсдийн судалгаа, сургалтын чиглэлийн дагуу газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, компаниудад зөвлөх үйлчилгээ үзүүлж жил бүр хамтран ажиллахаас гадна мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагуудад гишүүнчлэлээр ажилладаг байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын оролцсон төсөл, хөтөлбөрийн тоо жилээс жилд нэмэгдэж 2013 онтой харьцуулахад 2017 онд 11 ажил буюу 27,7 хувиар нэмэгдсэн байна. Мэргэжлийн хөтөлбөрийн хичээл заадаг багш нар өөрсдийн судалгаа, сургалтын чиглэлийн дагуу газар тариалан эрхэлдэг аж ахуй нэгж, компаниудад зөвлөх үйлчилгээ үзүүлж жил бүр хамтран ажиллахаас гадна мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагуудад гишүүнчлэлээр ажилладаг байна.

Анхаарах асуудал:

- Ахисан түвшний сургалтад тухайн сургуулийн үндсэн багш нараас гадна ХАА-н чиглэлийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын эрдэмтэн судлаачдын татан оролцуулах.
- Малын тэжээлийн нэг, олон наст ургамлын талаарх судалгааны ажил нь Агроэкологийн сургуульд ихээхэн ач холбогдолтой судалгааны чиглэл болох нь харагдаж байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрөө боловсруулахдаа эрдэм шинжилгээний байгууллагын мэргэжлийн чиглэлийн сектор, лаборатори, эрдэмтдээс санал авч ажилдаа хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Газар тариалангийн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа агрономиудаас санал авч болж байгаагаа бүр өргөтгөөд судалгааны шинжилгээний байгууллагатай өргөн хүрээтэй хамтран ажиллахаас гадна Монгол улсын шинжлэх ухааны байгууллагуудын үйл ажиллагаатай танилцуулж, судалгаа шинжилгээний ажлын үр дүнгийн талаар эрдэмтдээр лекц уншуулах зэрэг олон олон шинэлэг ажлыг зохион байгуулах хэрэгтэй.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, магистрт элсэн суралцах харилцааг зохицуулахад шаардлагатай эрх зүйн баримт бичиг, хууль, дүрэм, журмууд
- Магистрт элсэн суралцагчдын бүртгэл
- Гадаад оюутны элсэлтийн материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС нь “Агрономи” мэргэжлийн магистрын хөтөлбөрийг 4 удаа шинэчлэн сайжруулсан баялаг туршлагатай тул хэрэгжүүлэх бүрэн боломжтой.

Анхаарах асуудал:

- Тайланг 2013-2017 оны тоо, материалыг нэгтгэн дүгнэж бичсэн байна. Сүүлийн жилүүдийн (2018, 2019 оны) тоо, материалыг нэмэх шаардлагатай.

Зөвлөмж:

- Магистрт элсэгчдийн тоог нэмэгдүүлэх

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутнууд, магистрантуудын дунд явуулсан сэтгэл ханамжийн судалгааны материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрт суралцагчдад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхэд МДС, бүрэлдэхүүн сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн захирал, мэргэжлийн тэнхим, хөтөлбөрийн хороо, магистр хамгаалуулах зөвлөл, профессорын баг, эрдэм шинжилгээний ажлын удирдагч нарын үйл ажиллагаа суралцагчидтай хэр хамааралтай байгаа талаарх мэдээллийг кодлон программд оруулж загварчилсан нь сайшаалтай байна.
- Магистрын сургалтын төлөвлөгөөндөө 2017 онд өөрчлөлт оруулж “Судлаачийн ёс зүй” хичээлийг 2 кредит цаг үзэхээр тусгаж өгсөн нь магистрантуудад судлаачийн ёс зүйн талаарх үндсэн ойлголт, онол үзэл баримтлал, суурь хандлагууд, судалгааны ажил хийхдээ баримтлах ёс зүйн үндсэн зарчмууд, судлаачийн үүрэг хариуцлагын талаар мэдлэг олгоход маш чухал зүйл болсон гэж үзэж байна.

Анхаарах асуудал:

- Сэтгэл ханамжийн судалгаанаас үзэхэд эрдэм шинжилгээний ажлын удирдагчийн үйл ажиллагаа сул байгаа нь харагдсан. Тиймээс судалгааны ажлын арга зүйг боловсруулахаас эхлэн лабораторийн болон хээрийн туршилтын явцад хамтран ажиллах, магистрантын ганцаарчилсан төлөвлөгөөний гүйцэтгэлд удирдагч нь тогтмол хяналт тавьж байх шаардлагатай байна.
- Тайланд, зохион байгуулсан сургалт, арга хэмжээний талаар дурдсан боловч ямар сургалтыг хэдийд зохион байгуулсан, хэчнээн хүн хамрагдсан зэрэг нь тодорхойгүй байгааг анхаарах нь зүйтэй.

Зөвлөмж:

- Магистрт шинээр элсэн суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлагыг нэмэгдүүлэх.
- Магистрт элсэгчдийн судалгааны ажлын сэдэв сонголтод анхаарах.
- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйл ажиллагаа, үйлчилгээний чанарт хяналт сайн тавьж, үнэлгээ өгдөг байх.
- Хөдөө орон нутагт ажиллаж байгаа магистрантурт суралцагчдад мэдээллийг цаг тухайд нь хүргэдэг байх.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Магистрант оюутнуудын идэвх санаачилгыг дэмжих, үнэлэх ажлын төлөвлөгөө, үнэлгээний систем

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:**Анхаарах асуудал:**

- Ахисан түвшний суралцагчдыг сайн дурын ажилд татан оролцуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах.
- Магистрант оюутнуудыг суралцаж байх хугацаанд нь эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах.
- Магистрант оюутнуудын дунд бие даасан мэргэжлийн болон сайн дурын холбоо, клуб байдаггүй.

Зөвлөмж:

- Ахисан түвшний суралцагчдын холбоог шинээр байгуулах, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн батлуулж ажилласнаар оюутны олон нийтийн оролцоо нэмэгдэж, хамтын ажиллагаанд эерэг дүн үзүүлэх болно.
- Магистрантурт суралцагчдыг урамшуулал, тэтгэлэг, хөнгөлөлтөд сайн хамруулж байх.
- Суралцагчдыг дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрт хамруулах, судалгааны арга зүй эзэмших, туршилт судалгаа явуулахад нь дэмжлэг үзүүлж сургалтын төлбөрийн тодорхой хувийг зарцуулдаг байх.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн захирлын 2014 оны 398 -р тушаалаар баталсан ХААИС-ийн оюутны шилжилт, хөдөлгөөний журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС нь Монгол улсын Агрономи дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэж ирсэн арвин туршлагатай.

Анхаарах асуудал:

- Өөр мэргэжлээс шилжин суралцагчдын нэмж судлах шаардлагатай зөрүү хичээлийн сургалтын явц, чанарт анхаарал сайн тавих шаардлагатай.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 1997 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 59 тоот тушаалаар баталсан “Дээд боловсролын төгсөлтийн шалгалтын үлгэрчилсэн журам”, 2006 оны “Дээд боловсролын диплом олгох журам”, 2007 оны тус сургуулийн “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч салбар нь БШУ-ны сайдын 2014 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А/370 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”, БСШУ-ы сайдын 2006 оны 12-р сарын 29-ний өдрийн №480 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын диплом олгох журам”, мөн сайдын 2007 оны 187 тоот тушаал, тус сургуулийн “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”- ийг тус тус үндэслэн ХААИС-ийн магистр, докторын сургалт, судалгааны ажил, төгсөлтийн баримт бичгийг бүрдүүлэх, олгох ажлыг зохион байгуулдаг, хичээлийн үнэлгээг ХААИС- ийн захирлын 2017 оны 08 сарын 31-ний өдрийн А/187 тоот тушаалаар батлагдсан “Ахисан түвшинд суралцагчдыг үнэлэх үнэлгээний журам”- ыг мөрдлөг болгон ажилладаг.

Анхаарах асуудал:

- Магистрантурт суралцагчдын хэчнээн нь төгсөлтийн баримт бичиг авсныг баримтжуулах шаардлагатай.

Зөвлөмж:

- Санамж бичиг, гэрээ, хэлэлцээр байгуулах замаар гадаадаас магистрт элсэн суралцагчдын тоог нэмэгдүүлэх хэрэгтэй.
- Олон улсад суралцахад шаардлагатай төгсөлтийн баримт бичгийн нэмэлт хавсралт (*Diploma Supplement*)- ыг үйлдэх ажлыг эхлүүлэх, хэрэгжүүлэх нь зүйтэй.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн сонгон шалгаруулалт, багшийн албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлага нь ХААИС-ийн захирлын 2014 оны 01-р сарын 29-ний өдрийн 23 тоот тушаалаар батлагдсан “ХААИС-д профессор, багш ажиллуулах журам”-ын дагуу Боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, ХААИС-ийн дүрэмд нийцүүлэн зохицуулагддаг. (www.muls.edu.mn).
- Багшид тавигдах шаардлага хангасан, магистраас дээш зэрэг, цолтой багшийг нээлттэй сонгон шалгаруулж авдаг
- Тус сургуулийн нийт багш нар ХААИС-ийн бакалаврын сургалтын журмын дагуу сургалтын ажил явуулдаг бөгөөд ажлын үр дүнг ХААИС-ийн багш нарын сургалтын ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг тооцох журмын дагуу дүгнэдэг. Энэхүү журам ХААИС-ийн ректорын 2014 оны 01-р сарын 29-ний өдрийн 23 тоот тушаалаар шинэчлэгдэн батлагдсан болно. Энэ журмын хүрээнд багшийг сонгон шалгаруулж авдаг.
- Багш нарын анкет, бүрдүүлсэн материалтай танилцсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын эрдмийн зэрэг, цол жил бүр нэмэгдэж мэдлэг чадвар, туршлага дээшилж чадваржиж байгаа нь тайлангийн материалаас харагдаж байна.
- Магистрт суралцагчдын тоо сүүлийн жилүүдэд өсөх, 1 багшид ноогдох магистрантын тоо нэмэгдэх хандлагатай байна.

Анхаарах асуудал:

- Багш нарын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарах.

Зөвлөмж:

- Багш нараа гадаад хэлний сургалтад хамруулах, хамтын ажиллагааны гэрээ бүхий сургуулиудад мэргэжил дээшлүүлэх, багш солилцох талаар санаачлага гаргах

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Агрономи ахисан түвшний хөтөлбөрт мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээл заадаг багш нар болон оюутан суралцагчдын дунд явуулсан сэтгэл ханамжийн судалгааны материалтай танилцсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн, ХААИС-ийн ректорын 2002 оны 11-р сарын 20-ны өдрийн 156 тоот тушаалаар батлагдсан. “Багшийн хөгжил” хөтөлбөртэй.
- Багш нарын багшлах ур чадварыг дээшлүүлэхэд байнга анхаарч гадаадын их дээд сургуультай байгуулсан гэрээг ашиглан мэргэжлээ дээшлүүлэх, судалгааны ажилд оролцох; докторантурт суралцахад төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх; улсын болон олон улсын төсөл хөтөлбөр, гэрээт ажлын удирдагч, гүйцэтгэгчээр оролцох; ХААИС дээр хичээллэдэг гадаад хэл, мэдээлэл зүй, мэргэжлийн ахисан түвшний сургалтад оролцоход төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх; шинээр ажилд орсон залуу багш эхний жилдээ цагийн хөнгөлөлт эдлэх;
- Багшлах ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдах, мөн багшлах болон эрдэм шинжилгээний ажилд дур сонирхолтойгоо харуулсан, цаашид ХААИС-д тогтвор суурьшилтай ажиллах хүнийг гадаадад мэргэжлийн болон докторын сургалтад ХААИС-ийн захиалгаар хамруулах, хамтын судалгааны ажил хийх боломж олгох зэргээр багш нарыг дэмжин ажилладаг.

Анхаарах асуудал:

- Багшлах боловсон хүчний нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг дээшлүүлэхэд анхаарах.
- Сургалт, судалгааны ажлын чанарыг сайжруулахын тулд лабораторийн орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах, судалгааны арга зүйг шинжлэх ухааны түвшинд эзэмшүүлэх, оюутнуудыг эрдэм шинжилгээний ажилд дур сонирхолтой болгох

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөдөө аж ахуйн их сургууль нь судалгааны их сургууль болох зорилгын хүрээнд оюутан бүр судлаач байх, профессор бүр мэдлэгийн менежер байх, профессор судлаач бүр өөрийнхөө судалгаан дээр суурилсан гарааны компаниудыг байгуулах гэсэн томоохон зорилт тавиад ажилладаг.
- Агрономи мэргэжлийн хөтөлбөрийн сургалт нь дадлагад илүү суурилсан учраас магистрант оюутан бүр судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэн боловсролын зэргээ

ахиулж, түүнийг үйлдвэрлэлд хэрэгжүүлэхэд багш нар нь хамтран ажиллаж, удирдан чиглүүлж, мэдлэгээр хангаж ажиллаж байна. Энэ нь Агрономийн ахисан түвшний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөн цар хүрээнд явуулах, цаашдаа өсөн дэвших боломжийг хангаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Агрономи мэргэжлийн магистрын хөтөлбөрт хичээл заадаг багш нар нь ХАА-н салбарын өмнө тулгамдаж буй зорилтыг шийдвэрлэх зорилгоор ШУТ-ийн, онолын суурь судалгааны, инновацын, олон улсын болон ХААИС-ийн санхүүжилттэй төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх боломжтой байдаг.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулж байгаа төсвийг судлаач багш бүр өөрийн хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрөөс бүрдүүлдэг бөгөөд 1-2 магистрант оюутныг дагалдуулан сургаж байна.
- Судалгааны ажлын арга зүй боловсруулж туршлага судалгааны үр дүнгээр ахисан түвшний оюутнууд боловсролын зэргээ ахиулж, багш нар жил бүр судлаач ахисан түвшний оюутнуудыг удирдан судалгаа шинжилгээний ажлууд хийснээр орчин үеийн судалгааны арга зүй болон судалгаа нь шинэчлэгдэн сайжирч байна.

Анхаарах асуудал:

- Эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээр багш нарын дотоодод тавьсан илтгэл, хэвлүүлсэн өгүүлэл жил бүр өссөн үзүүлэлттэй байгаа ч харин гадаадын бүтээлд нийтлүүлсэн өгүүлэл, ялангуяа IF-тэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо бага байгаад анхаарах нь зүйтэй.

Зөвлөмж:

- Өөрсдийн судалгааныхаа ажлын үр дүнг ашиглан олон улсын түвшинд хянагддаг мэргэжлийн сэтгүүлүүдэд өгүүлэл хэвлүүлэх.
- Магистрын сургалтын хөтөлбөрт орчин үеийн дэвшилтэт техник, технологитой холбоотой хичээлүүдийг оруулж ахисан түвшний оюутнуудад заах хэрэгтэй байна. Учир нь энэ талын мэдлэг дулимагаас үйлдвэрлэл дээр хоцрогдох байдал ажиглагдаж байна.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багш нарын өөрийн үнэлгээний тайлан, хөндлөнгийн үнэлгээний материал, цагийн ачаалал тооцсон материал
- Багш нарын сургалтандаа хэрэглэж байгаа арга технологи, ур чадварын талаарх оюутны сэтгэл ханамжийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тэнхимийн эрхлэгч, багш, ажилтан бүр хичээлийн жилийн улирал бүрд хийх ажлаа сар, сараар төлөвлөн улирлын эцэст өөрийн үнэлгээний тайланг бичиж хамгаалдаг нь хамт олны дотоод хяналт үнэлгээг хэрэгжүүлэх үндсэн арга болж байна.
- Өмнөх жилүүдэд багш бүр хамт олондоо тайлангаа танилцуулж хувь хүн өөрийгөө үнэлдэг байсныг сүүлийн жилүүдэд хамт олноороо хэлэлцэн тэнхимд байгаа Агрономи, Газар тариалангаар мэргэшсэн фермерийн аж ахуй, Хөрс судлал-агрохими, Ургамал хамгаалал хорио цээрийн үнэлгээ гэсэн 4 мэргэжлийн хөтөлбөрийн хорооны зохицуулагчид, тэнхимийн эрхлэгчтэй хамтран комисс болж багшийн тайлан, нотолгоог үзэж бодитойгоор үнэлж дүгнэх болсон байна. Мөн 4-5 жил тутамд аттестатчлалд хамруулан хөндлөнгийн үнэлгээ өгдөг. Мөн тус сургууль нь багш нарын ажлын гүйцэтгэлийг өөрийн үнэлгээний тайлангаар дүгнэхээс гадна жил бүр бүрэлдэхүүний сургуулийн шилдэг сурган хүмүүжүүлэгч багш, шилдэг судлаач багш, шилдэг залуу багш гэсэн номинациар багш болон тэнхимийг шалгаруулдаг уламжлалтай.

Анхаарах асуудал:

- Сургалтыг шинэлэг арга зүй, технологи ашиглан заахад түлхүү анхаарах.
- Хичээлийн хуваарь оновчтой бус байдгаас хичээлдээ хамрагдах байдал харилцан адилгүй байдагт анхаарах.
- Ахисан түвшний оюутнуудад хичээл заадаг багш нарын цагийн үнэлгээг нэмэгдүүлэх.

Зөвлөмж:

- Оюутнуудын дунд явуулсан сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн сул үнэлэгдсэн зарим үзүүлэлтүүдэд цаашид анхаарч ажиллах.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө
- “Хаан кампус” стратегийн төлөвлөлт
- Гадаадын их, дээд сургуулиудтай хамтран хос хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ (Австрийн БОКУ-ийн их сургууль, БНСУ-ын Сөүлийн их сургууль, Хангёны үндэсний

их сургууль, ОХУ-ын Буриад улсын ХААИС, ХБНГУ-ын Вайнштефаны мэргэжлийн их сургууль, БНХАУ-ын Хөх хотын ХААИС)

- БМИҮЗ-ийн шинэ шалгуурын дагуу ахиц дэвшлийн тайлан
- Магистрантуудаас сургалтын талаар авсан сэтгэл ханамжийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Агрономи магистрын хөтөлбөрийг хянах, үнэлгээ өгөх, зохицуулах ажлыг 2014 оноос эхлэн Агрономи мэргэжлийн хөтөлбөрийн хороо гүйцэтгэн ажиллаж байна.
- Сэтгэл ханамжийн судалгааг байнга явуулдаг.
- Чанарын үнэлгээ, баталгаажуулалтын чиглэлээр шинээр алба байгуулан дүрэм журам боловсруулах ажил эхэлсэн байна.

Анхаарах асуудал:

- Сургуулийн хэмжээний чанарын үнэлгээ, баталгаажуулалтын талаар дотоод дүрэм журам байхгүй.
- Чанарын үнэлгээ хийх тогтолцоо бүрдээгүй.

Зөвлөмж:

- Чанарын үнэлгээ, баталгаажуулалтыг хянах дүгнэх дүрэм журам боловсруулах гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах.
- Сэтгэл ханамжийн судалгаандаа байнгын шинжилгээ хийж түүнээс гарсан үр дүнг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээний төлөвлөгөө гаргах

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн, хөтөлбөртөө өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ
- Багшийн харилцааны ур чадварт өгсөн сэтгэл ханамжийн судалгааны дүн
- Ажил эрхлэлтийн судалгаа
- Агрономи мэргэжлийн чиглэлээр 2018-2019 онд магистрын зэрэг хамгаалсан судалгаа
- Агрономи мэргэжлийн магистрантын ангийг төгсөгчид Монгол улсын Газар тариалангийн шинжлэх ухаан – сургалт үйлдвэрлэлийн бүхий л салбарт амжилттай ажиллаж байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчид ажлын байраар бүрэн хангагддаг.
- Агрономи магистрын хөтөлбөр эрэлт өндөртэй байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчдад газар тариалангийн салбарт сүүлийн үед ашиглаж буй шинэ техник тоног төхөөрөмжийг шууд ашиглаж чадах чадвар дадал эзэмшүүлэх.

Зөвлөмж:

- Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон үйлдвэрлэл аж ахуйн газрууд, мэргэжлийн холбооны удирдлагуудтай байнгын холбоо харилцаатай байж тэдний санал хүсэлтийг сургалтын хөтөлбөр болон хичээлийн төлөвлөгөө, агуулгадаа тусгаж байх.
- Үйлдвэрлэл судалгааны ажилд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, захиалгат болон гэрээт ажилд оюутнуудыг оролцуулах.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Австрийн БОКУ-ийн их сургууль, БНСУ-ын Сөүлийн их сургууль, Хангёны үндэсний их сургууль, ОХУ-ын Буриад улсын ХААИС, ХБНГУ-ын Вайнштефаны мэргэжлийн их сургууль, БНХАУ-ын Хөх хотын ХААИС-тай хамтран ажиллах гэрээ
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал
- Улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр улсын хэмжээнд зөвхөн ХААИС-д хэрэгждэг.
- Гадаадын сургуулиудад богино хугацаагаар болон хос хөтөлбөрт хамрагдан суралцдаг.

Анхаарах асуудал:

- Чанарын баталгаажуулалтын багийн үйл ажиллагаа жигд бус байна.
- Бакалаврын болон ахисан түвшний суралцагчдын элсэлт нэмэгдэхгүй байна.

Зөвлөмж:

- Амжиргааны түвшин муутай суралцагч их байдгаас сургалтын төлбөрөө төлж дийлэхгүй сургуулиа орхих явдал их байгаа тул төрийн зүгээс тодорхой дэмжлэг үзүүлэх
- Агрономи магистрын хөтөлбөрийн танхимын сургалтын цаг хугацааг газар тариалангийн үйлдвэрлэл явагддаг цаг хугацаатай уяалдуулан зохицуулалт хийх.
- Цахим сургалтаар хичээллэх нөхцөл бүрдүүлж, зайн сургалтыг дэмжих.

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн хэрэгжилт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшлах бүрэлдэхүүн	2			
7	Чанарын үнэлгээ баталгаажилт	2	7.1		Чанарын үнэлгээ баталгаажуулалтын үйл ажиллагаа сургуулийн хэмжээнд бүрэн төлөвшөөгүй
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Агроэкологийн сургуулийн “Агрономи” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Хөдөө аж ахуй, ой загасны аж ахуй, мал эмнэлзүйн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч: В.Батцэнгэл

Шинжээчийн багийн гишүүн: И.Отгонбаатар

Шинжээчийн багийн гишүүн: Д.Алимаа

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
Хөтөлбөрийн нэр	Агрономи
Хөтөлбөрийн индекс	Е 08110101
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	Агрономи хөтөлбөрөөс бусад хөтөлбөрөөр суралцан төгсөөд тус магистрын хөтөлбөрт суралцаж буй суралцагч нарт зориулан хөтөлбөрөө сайжруулах;
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	Хамтран ажилладаг гадаадын их дээд сургуулиудын сургалтын үйл ажиллагааны талаарх зарим дэвшилтэт аргыг өөрсдийн нөхцөл бололцоонд тохируулан нэвтрүүлэх;
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	Орчин үеийн хөдөө аж ахуйн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах тал дээр санаачилга гаргах;
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ тухайн тэнхимийн багш нараас гадна энэ салбарын туршлагатай эрдэмтэн судлаач нарыг татан оролцуулах;
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	Үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй магистрант оюутнуудын онцлог нөхцөл байдалд зохицуулан хичээлийн хуваарь, цагийг уян хатан зохицуулалт хийж байх;
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	Багш нарын мэргэжлийн болон гадаад хэлний чадварыг сайжруулахад зориулсан байнгын хөтөлбөрийг бий болгох;
ШААРДЛАГА	
<i>/хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/</i>	
Шалгуур 7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт	Чанарын үнэлгээ баталгаажуулалтын асуудлыг хариуцсан албаныхаа үйл ажиллагааг сайжруулах, чанарын үнэлгээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдээ тодорхой болгох;

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэрс	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1.	Б.Одгэрэл	Тэнхимийн эрхлэгч	Доктор	25	Хээрийн судалгааны арга зүй
2.	Ш.Лхам	Багш	Доктор, дэд проф.	40	Судлаачийн ёс зүй
3.	М.Мөнхзул	Багш	Доктор	18	Судлаачийн ёс зүй
4.	О.Мөнхжаргал	Багш	Доктор /Sc.D/, проф.	33	Тогтвортой газар тариалангийн систем, Усалгаатай газар тариалангийн судалгааны арга, Агроемелиорацийн аргууд
5.	Д.Ундармаа	Багш	Доктор, дэд проф.	24	Ургамал хамгаалах цогц аргын менежмент
6.	Б.Энхжаргал	Багш	Доктор	16	
7.	А.Буянбаатар	Багш	Доктор, дэд проф.	15	Хөрс судлал
8.	Н.Дамбадаржаа	Багш	Доктор	11	

II. Оюутны нэрс

№	Нэрс	Курс	Сонгосон байдал
1.	Б.Мандухай	I	Улаанбаатар хот
2.	Б.Нямбуу	II	Улаанбаатар хот
3.	Зандармаа	II	Улаанбаатар хот
4.	Б.Загдрагчаа	II	Өмнөговь аймаг
5.	Хадбаатар	II	Сүхбаатар аймаг
6.	Одгэрэл	II	Улаанбаатар хот
7.	Мөнгөнчимэг	III	Өмнөговь аймаг
8.	Мөнхбаатар	II	Төв аймаг
9.	Баттогтох	III	Улаанбаатар хот
10.	Алтансүх	III	Дорнод аймаг

III. Ажил олгогчдын нэрс

№	Нэрс	Байгууллага	Албан тушаал
1.	Н.Баярсүх	Дархан УГТХ	УГТХ - ийн захирал
2.	Л.Бямбасүрэн	УХХүрээлэн	УХЭШХ – ийн захирал
3.	Ө.Болдсайхан	Энсада ХХК	Захирал
4.	Дэжидмаа	МААЭШХ	Э/Ш – ний ажилтан
5.	С.Онон	Энх Ногоон тал ХХК	Менежер

6.	Гантулга	Эрдэнэс таван толгой	Байгаль орчны хэлтсийн дарга
7.	Төрмандах	Монгол ногоо	Төслийн зохицуулагч
8.	Ч.Батбаяр	Экологийн бордоо	Захирал
9.	Х.Баасандорж	Атрын шим ХХК	Захирал
10.	Д.Насанжаргал	Жимс ЖҮХолбоо	Тэргүүн

IV. Төгсөгчдийн нэрс

№	Нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал
1.	Г.Ариунчимэг	2019	Архангай аймаг МСҮТийн багш
2.	В.Цэгмэд	2018	Хувиараа
3.	С.Гочоосүрэн	2016	Нийслэлийн ХААГазар
4.	Г.Рэгзэдмаа	2017	Хэнтий аймаг дахь ПТ коллежид фермерийн багш
5.	Б.Болортөгс	2015	Бридж групп
6.	Ц.Баттуяа	2016	Хувиараа
7.	Г.Пүрэвбаатар	2018	Бат-Өндөр хайрхан ХХК
8.	П.Сүхбаатар	2010	МААЭШХ
9.	Х.Мөнхцэцэг	2016	Инженер геодези
10	Болорхундага	2013	Эрдэнэс таван толгой ХХК

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/



**ХӨДӨӨ АЖ АХУЙН НХ СУРГУУЛЬ
АГРОЭКОЛОГИЙН СУРГУУЛЬ**

17024 Улаанбаатар хот, Хэн-Уул дүүрэг,
11 дүгээр хороо, Зайсан 5, Утас: 7510 7777 243
И-мэйл: agroecology@mnu.edu.mn
Вэб сайт: www.mnu.edu.mn

2020.10.13 № 05/288
танай _____-ны № _____-г

**Шинжээчийн тайлантай
танилцсан тухай**

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД**

Агрономийн магистрын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шинжээчийн тайлантай танилцлаа. Шинжээчид шалгуур үзүүлэлт тус бүрээр үнэлэлт дүгнэлт гаргаж зөвлөмж өгсөн байна. Эдгээртэй санал нэг байгаа бөгөөд зөвлөмжийг хүлээн авч цаашид үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэхээ үүгээр мэдэгдэж байна.

ЗАХИРАЛ



А.БУЯНБААТАР

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)

[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)

[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/